



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Их эзэн Чингис хааны нарэмжит талбай 1,  
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: [stategreatrural@parliament.mn](mailto:stategreatrural@parliament.mn)  
<http://www.parliament.mn>

2019.06.28 № 18

Асуулга тавих тухай

Бүгд Найрамдах Турк Улсын Истанбул хотод суугаа Ерөнхий консулын газрын дэд консул Б.Баттушиг, жолооч С.Эрдэнэбаяр нар энэ оны 5 дугаар сарын 3-ны өдөр ХБНГУ-ын Дрезден хотын хилийн шалган нэвтрүүлэх постоор Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газрын дипломат албан дугаар бүхий автомашинд их хэмжээгээр хар тамхи тээвэрлэж яваад ХБНГУ-д баривчлагдан шалгагдаж байгаа.

Хар тамхины олон улсын томоохон сүлжээнд Монгол Улсын төрийн тусгай албан хаагчид удаа дараа оролцсон байгаа нь ГХЯ-ны боловсон хүчний бодлого хэрхэн алдагдсан, тусгай эрх ямба эдэлдэг дипломат албыг улс төрийн наймааны бялуу хуваах хэрэгсэл болгож, мэргэжил, боловсрол, туршлага зэргийг үл харгалзан ах дүү, төрөл садан, танил тал, найз нөхдөө томилж, явуулдаг байдал эх захaa алдаж, энэ асуудал зөвхөн Монгол улсын бус олон улсын хэмжээний асуудал болоод зогсохгүй манай улсад итгэх итгэл алдарч, Монгол Улсын нэр хүндийг дэлхийн тавцанд хүчтэй унагаж байгааг Та анхааралдаа авсан гэдэгт итгэж байна.

ХБНГУ-д баригдсан хоёр дипломат албан тушаалтнуудын хувьд зөвхөн баригдаж ил болсон нь, гэтэл цаана нь илчлэгдээгүй хичнээн эрх ямбатан энэ мэт гэмт хэрэг үйлдсээр байгаа нь тодорхойгүй байна.

Баривчлагдан шалгагдаж буй хоёр хүний хувьд энэ нь нэг удаагийн бус олон удаагийн давтамжтай гэх бөгөөд Тагнуулын ерөнхий газарт ажиллаж байсан шалгаж байсан гэх мэдээлэл байгаа нь нэг жилийн өмнө БНТУ-д дипломат албанд томилогдсон дээрх этгээдүүд өмнө нь томилогдсон Тайландын Вант Улс, ОХУ-д консулаар ажиллахдаа ч энэ төрлийн гэмт хэргийг үйлдсэн байж болзошгүй байдлыг илэрхийлж байна.

Үүнээс гадна БНТУ-ын Истанбул хотод сууж байсан Ерөнхий консулын газрын дэд консул Б.Баттушигийг өмнө нь Тагнуулын ерөнхий газарт ажиллаж байсан гэдгийг Тагнуулын ерөнхий газраас мэдэгдсэн байна. Ийнхүү мэдээлсэн нь Монгол улс ХБНГУ эсвэл БНТУ-д тагнуулын үйл ажиллагаа явуулсан байж болзошгүй гэх шууд хардлагыг тухайн улс орнуудад өгч байна. Чиг үүрэг, албан тушаалтын хир хэмжээгээ мэддэггүй албан тушаалтнуудын санаатай болон санамсаргүй олон

алдаанаас Монгол Улсыг дипломат албан тушаалтан нэрийн дор тагнуулын тусгай ажиллагаа явуулсан байж болзошгүй гэдэг хардлагад өртүүлсэн байна.

Аливаа улсын болон Олон улсын хуулиар тагнуулын этгээд илчлэгдэхэд хурвэл 24 цагийн дотор тухайн улсыг орхин гарах ёстой байдаг, гэтэл хар тамхи зөөвөрлөж яваад баригдсан дипломат албан тушаалтыг тагнуулын ажилтан байсан гэж дэлхий дахинаа зарласан үйлдэл нь БНТУ-ын Истанбул хотод сууж байсан Ерөнхий консулын газрын дэд консул Б.Баттушиг гэх этгээдийг хар тамхины онц ноцтой гэмт хэрэгтэн төдийгүй тагнуулын үйл ажиллагаа явуулсан гэх хатуу ял зэмд давхар унагажээ.

Дээрх нөхцөл байдлуудаас үүдэн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайд Танд дараах асуулгыг тавьж байна.

1. БНТУ-ын Истанбул хотод сууж байсан Ерөнхий консулын газрын дэд консул Б.Баттушиг нь тагнуулын байгууллагад ажиллаж байсан нь төрийн нууцад хамаарч байгаа эсэх; Хэрэв төрийн нууцад хамаарч байгаа бол нууц задруулсан албан тушаалтанд хариуцлага тооцсон эсэх талаар;

2. Дээрх хоёр дипломат албан тушаалтны хувьд энэ нь нэг удаагийн бус давтамжтай үйлдэл гэх бөгөөд Тагнуулын ерөнхий газар олон жил мөрдөж байсан гэх мэдээлэл байна. Өмнө нь олон удаа үйлдсэн гэмт хэргийн талаар мэдсээр байж яагаад Гадаад харилцааны сайд өөрийн бүрэн эрхийн хүрээнд эгүүлэн дуудаж, холбогдох байгууллагад хандан, хариуцлага тооцуулалгүйгээр гадаад улсын тусгай албананд шууд хандсан талаар;


3. Монгол Улс Европын холбооны улсуудтай эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулаагүй байхад Гадаад харилцааны сайд манай Элчин сайдын яамдууд руу чиглэсэн үйл ажиллагаа явуулах шаардлагатай талаар албан бичиг явуулах эрхтэй эсэх, Монгол улсын Ерөнхий сайд Тантай зөвшилцсөн эсэх талаар;

4. Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд дарга, хурандаа Р. Отгонжаргал “энэ сарын 17-нд Польшийн прокурорын байгууллагаас хоёр улсын эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний дагуу ирүүлсэн мөрдөн байцаагчийн даалгаврыг хүлээн авч, нийт Монголд байгаа 70 иргэнтэй холбоотой асуудлыг тодотгох санал ирснийг судалж, Польш улсад албан ёсны хариуг нь өгсөн” хэмээн мэдэгдсэн. Польшийн прокурорын байгууллагад Монгол улсын 70 иргэний талаар явуулсан мэдээлэл, болон тэдгээр 70 иргэний хэд нь дипломат эрх ямба эдэлж байсан, одоо хэд нь энэхүү эрхээ эдэлж дипломат албан тушаал хашиж байгаа талаар болон төрийн албанад ажиллаж байгаа эсэх талаар;

5. Монгол улсыг гадаад улсад төлөөлж байгаа дипломат консулын газарт ажиллаж байгаа болон томилогдох гэж байгаа албан тушаалтнуудад тавигдах шаардлага, хариуцлагыг өндөржүүлэх талаар ямар арга хэмжээ авч байгаа талаар дэлгэрэнгүй хариу ирүүлнэ үү.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг Тандаас хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



С.ЭРДЭНЭ

0000000083